



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/129/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Д.Энхжаргал

Утас: 88026672

цахим хаяг: Enkhjargald@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	16
<b>3.5.1 Төсвийн төлөвлөлт</b> .....	16
<b>3.5.2 Төсвийн гүйцэтгэл</b> .....	16
<b>3.5.3 Нэмэлт төсөв</b> .....	18
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	16
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	18
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	18
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	18
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	19
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	19
<b>4.4.2 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	19
<b>4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	19
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал</b> .....	20
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	20
<b>5.2 Албан шаардлага</b> .....	20
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
64000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

**ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Х.БАЯРЛАХ ТАНАА**

2023.03.25 № 2/121  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

#### **Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, Засаг даргын нөөц хөрөнгө, нэмэлт санхүүжилтийн дансаар хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний анхан шатны баримтын бүрдэл, хэрэгжүүлсэн ажлын тайлан хэрэгжилт дутуу, төсвөөс бэлэг дурсгалын зардал санхүүжүүлсэн, бусад байгууллагын ажилтнуудад урамшуулал олгосон, чөлөөт уран бүтээлчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн, түрээсийн орлогын 40 хувь төсөвт төвлөрүүлээгүй, түрээсийн орлогын тооцоо боддоггүй, халуун усны түрээсийн тооцоо хийгээгүй, жолоочийн замын хуудасгүй шатахуун зарцуулсан, шатахууны тооцоо боддоггүй, төрийн хэмнэлтийн хууль зөрчсөн зардал гаргасан зэрэг 149.1 сая төгрөгийн зөрчлүүд илэрсэн нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБӨУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Мөн улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн 1,029.9 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байсныг залруулав.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд 9 дүгээр цэцэрлэгийн тохижилтод 19.0 сая, цэргийн ангийн камержуулалтад 4.2 сая, 1 дүгээр сургуулийн тоног төхөөрөмж 30.0 сая, цагдаагийн газарт драйвэр 7.9 сая, онцгой байдлын газрын дээврийн засвар 20.0 сая, гадна хогийн сав хийхэд 9.4 сая, прокурорын байгууллагын үүдний хэсэгт услалтын систем хийх 3.0 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

021020180

### **Аудитын гол асуудал**

Багуудад байршилтай цагаан идээний цэгүүд, халуун ус, байгууллагын хурлын заалны зэрэгт ашиглалтын түрээсийн гэрээ байгуулан дотоод хяналт хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Жаргалант сумын иргэдийн нийтийн тээврийн үйлчилгээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3 автобус нийлүүлэгдэж, 2022 онд сумын төсвөөс 80.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг Батхөсөгтөн ХХК-д олгосон ч гэрээний үүргийн биелэлтийг тооцон, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах шаардлагатай байна.

### **Аудитын гол асуудал**

Өмнөх онуудад төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг байсан Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн санхүүгийн тайлангийн тогтмол зардлаас бусад үзүүлэлтүүд системийн дээд байгууллагын тайланд нэгтгэгдэх бодлогын өөрчлөлт бий болсонтой холбоотойгоор эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд нөлөөлөл бүхий өөрчлөлтүүд орсон байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Сумын ИТХ-ын 8/02 тогтоолоор Сумын засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг 88.8 буюу “Хангалттай” гэж үнэлсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>80,854,205.69</u></b>	<b><u>136,376,935.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	276,789.69	132,381.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	276,789.69	132,381.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	26,108,907.00	36,908,907.00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	26,108,907.00	36,908,907.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	22,138,238.00	30,538,238.00
34713	Цалингийн урьдчилгаа	3,970,669.00	6,370,669.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	54,468,509.00	99,335,647.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	54,468,509.00	99,335,647.00
35410	Бичиг хэргийн материал	1,610,500.00	1,620,200.00
35420	Аж ахуйн материал	51,008,009.00	97,715,447.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>4,074,669,889.45</u></b>	<b><u>5,344,552,833.96</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	4,074,669,889.45	5,344,552,833.96
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,687,261,889.45	4,955,144,833.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,812,685,997.78	5,017,311,366.78
39202	Хуримтлагдсан элэгдэл	(328,467,755.09)	(444,491,335.81)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	157,072,800.00	277,072,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(115,411,519.60)	(132,728,079.76)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	190,693,629.00	293,143,629.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(101,102,112.83)	(123,898,695.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	96,978,882.00	106,158,882.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(42,611,531.81)	(54,847,232.26)
39217	Ном	17,423,500.00	17,423,500.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	387,408,000.00	389,408,000.00
39301	Програм хангамж	1,450,000.00	1,450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,450,000.00)	(1,450,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	387,408,000.00	389,408,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>4,155,524,095.14</u></b>	<b><u>5,480,929,768.96</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>11,237,841.00</u></b>	<b><u>20,894,175.31</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	11,237,841.00	20,894,175.31
<b>413</b>	<b>Өглөг</b>	11,237,841.00	20,894,175.31
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	4,391,975.31
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	7,882,241.00	968,600.00
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	3,355,600.00	14,605,600.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	928,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	928,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>3,114,654,082.44</u></b>	<b><u>5,460,035,593.65</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,114,654,082.44	5,460,035,593.65
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	1,029,632,171.70

51101	Өмч: - төрийн		1,029,632,171.70
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,832,599,917.90	4,148,349,257.41
51210	Өмнөх үеийн үр дүн	2,832,599,917.90	2,832,599,917.90
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,315,749,339.51
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	282,054,164.54	282,054,164.54
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>3,125,891,923.44</u></b>	<b><u>5,480,929,768.96</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,550,652,150.00</b>	<b>3,069,906,650.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,427,412,250.00</b>	<b>1,486,132,869.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,427,412,250.00	1,486,132,869.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,427,412,250.00	1,486,132,869.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	5,398,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,491,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,423,921,250.00	1,480,734,869.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,123,239,900.00</b>	<b>1,583,773,781.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	1,460,653,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,460,653,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	193,860,342.00	123,120,581.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	185,701,262.00	79,617,532.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,159,080.00	43,503,049.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	929,379,558.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	929,379,558.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,205,707,467.45</b>	<b>1,754,157,310.49</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,047,875,450.45</b>	<b>1,612,216,462.15</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,038,144,652.45	1,454,996,511.15
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	514,348,681.02	566,109,714.00
210101	Үндсэн цалин	360,699,542.00	391,331,525.00
210102	Нэмэгдэл	116,661,835.02	73,781,018.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,160,000.00	3,196,525.00
210104	Урамшуулал	-	18,330,372.00
210105	Гэрээт ажлын хөлс	33,827,304.00	79,470,274.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	67,465,912.10	71,485,186.00
210201	Тэтгэврийн даатгал	48,252,064.21	49,145,760.59
210202	Тэтгэмжийн даатгал	4,982,970.98	5,781,844.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,907,398.26	4,544,835.14

210204	Ажилгүйдлийн даатгал	982,805.81	1,089,968.71
210205	Эрүүл мэндийн даатгал	9,340,672.84	10,922,777.31
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	113,399,741.00	106,261,543.00
210301	Гэрэл, цахилгаан	9,379,102.00	11,116,628.00
210302	Түлш, халаалт	94,088,726.00	86,959,248.00
210303	Цэвэр, бохир ус	9,931,913.00	8,185,667.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	63,808,351.00	77,616,008.00
210401	Бичиг хэрэг	7,999,400.00	17,287,600.00
210402	Тээвэр, шатахуун	17,516,900.00	20,782,022.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,805,100.00	3,578,560.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,244,306.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	25,232,645.00	35,967,826.00
210408	Бараа материал актгалсны зардал	10,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,808,600.00	1,438,950.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,708,600.00	1,155,000.00
210604	Урсгал засвар	100,000.00	283,950.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	400,000.00	2,843,900.00
210702	Дотоод албан томилолт	400,000.00	2,843,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	97,653,634.00	356,349,235.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	96,458,639.00	354,800,385.66
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	421,200.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	403,795.00	283,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	110,000.00	404,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,000.00	90,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	600,000.00
210807	Газрын төлбөр	170,000.00	170,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	177,259,733.33	272,891,974.49
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	48,277,988.00	102,394,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,882,250.00	2,124,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	125,099,495.33	168,372,424.49
<b>212</b>	<b>ТАТААС</b>	-	83,750,000.00
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	-	83,750,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох тагаас	-	83,750,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	9,730,798.00	73,469,951.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,863,700.00	41,842,794.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	37,288,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,863,700.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	4,554,594.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	2,757,226.00	31,627,157.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,757,226.00	31,627,157.00

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,109,872.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,109,872.00	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>157,832,017.00</b>	<b>141,940,848.34</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	157,832,017.00	141,940,848.34
220001	Барилга байгууламж	20,000,000.00	48,002,400.00
221001	Их засвар	-	-
222001	Тоног төхөөрөмж	4,750,000.00	31,622,448.34
223001	Бусад хөрөнгө	133,082,017.00	62,316,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>2,344,944,682.55</u></b>	<b><u>1,315,749,339.51</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	39,000.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	39,000.00	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(39,000.00)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>2,344,905,682.55</u></b>	<b><u>1,315,749,339.51</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,126,730,900.00</u></b>	<b><u>1,589,201,258.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,491,000.00</b>	<b>5,398,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,491,000.00	5,398,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,491,000.00	5,398,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	5,398,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,491,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>1,123,239,900.00</u></b>	<b><u>1,583,803,258.00</u></b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	-	1,460,653,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1,460,653,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	193,860,342.00	123,120,581.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	185,701,262.00	79,617,532.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,159,080.00	43,503,049.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	929,379,558.00	-
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	929,379,558.00	-
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	-	29,477.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	29,477.00

<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>906,856,243.00</b>	<b>1,381,664,424.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>906,856,243.00</b>	<b>1,381,664,424.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>896,405,245.00</b>	<b>1,224,444,473.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	520,154,244.00	572,786,477.00
210101	Үндсэн цалин	346,152,835.00	387,408,502.02
210102	Нэмэгдэл	97,246,295.00	75,797,567.98
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,972,706.00	3,197,647.00
210104	Урамшуулал	-	17,971,779.00
210105	Гэрээт ажлын хөлс	73,782,408.00	88,410,981.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	70,094,100.00	71,669,600.00
210201	Тэтгэврийн даатгал	49,325,400.00	48,735,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,192,200.00	5,588,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,153,800.00	4,732,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,038,400.00	1,146,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,384,300.00	11,467,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	105,517,500.00	113,903,784.00
210301	Гэрэл, цахилгаан	14,181,400.00	10,818,600.00
210302	Түлш, халаалт	74,330,800.00	88,434,800.00
210303	Цэвэр, бохир ус	17,005,300.00	14,650,384.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,506,953.00	31,104,260.00
210401	Бичиг хэрэг	8,479,000.00	11,386,300.00
210402	Тээвэр, шатахуун	12,056,900.00	16,109,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,208,053.00	3,578,560.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,763,000.00	30,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	835,900.00	810,340.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	835,900.00	810,340.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,318,500.00	2,465,120.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	244,700.00	19,660.00
210604	Урсгал засвар	8,073,800.00	2,445,460.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	400,000.00	1,783,900.00
210702	Дотоод албан томилолт	400,000.00	1,783,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	96,830,190.00	319,243,770.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	94,867,855.00	317,694,920.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	421,200.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	571,135.00	283,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	110,000.00	404,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,000.00	90,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000.00	600,000.00
210807	Газрын төлбөр	170,000.00	170,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	66,747,858.00	110,677,222.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,865,608.00	108,993,022.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,882,250.00	1,684,200.00
<b>212</b>	<b>ТАТААС</b>	<b>-</b>	<b>83,750,000.00</b>

2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-	83,750,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	-	83,750,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,450,998.00</b>	<b>73,469,951.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	5,583,900.00	41,842,794.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	35,138,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,863,700.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	720,200.00	6,704,594.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	2,757,226.00	31,627,157.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,757,226.00	31,627,157.00
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	2,109,872.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,109,872.00	-
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>219,874,657.00</u></b>	<b><u>207,536,834.00</u></b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>219,874,657.00</b>	<b>202,825,634.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>219,874,657.00</b>	<b>202,825,634.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	219,874,657.00	202,825,634.00
220001	Барилга байгууламж	14,660,000.00	68,873,800.00
221001	Их засвар	12,000,000.00	-
222001	Тоног төхөөрөмж	33,569,662.00	45,997,500.00
223001	Бусад хөрөнгө	159,644,995.00	87,954,334.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(219,874,657.00)</u></b>	<b><u>(202,825,634.00)</u></b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	4,711,200.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	=	=

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,029,632,171.70	282,054,164.54	486,394,235.35	1,798,080,571.59
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,029,632,171.70	282,054,164.54	486,394,235.35	1,798,080,571.59

C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			1,300,000.00	1,300,000.00
C07	Тайлант үеийн үр дүн			2,344,905,682.55	2,344,905,682.55
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,029,632,171.70	282,054,164.54	2,832,599,917.90	4,144,286,254.14
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,029,632,171.70	282,054,164.54	2,832,599,917.90	4,144,286,254.14
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,029,632,171.70	282,054,164.54	2,832,599,917.90	4,144,286,254.14
D08	Тайлант үеийн үр дүн			1,315,749,339.51	1,315,749,339.51
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,029,632,171.70	282,054,164.54	4,148,349,257.41	5,460,035,593.65

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,574,686,200	1,447,912,270
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,279,036,200	1,269,393,870
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,188,376,200	1,178,801,076
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	573,357,000	573,357,000
210101	Үндсэн цалин	385,696,000	384,979,857
210102	Нэмэгдэл	85,545,300	78,918,681
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,441,200	3,197,647
210104	Урамшуулал	0.00	17,971,779
210105	Гэрээт ажлын хөлс	98,674,500	88,289,036
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	71,669,600	71,669,600
210201	Тэтгэврийн даатгал	48,735,400	48,735,400
210202	Тэтгэмжийн даатгал	5,588,100	5,588,100
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,732,300	4,732,300
210204	Ажилгүйдлийн даатгал	1,146,700	1,146,700
210205	Эрүүл мэндийн даатгал	11,467,100	11,467,100
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	120,920,000	113,903,784
210301	Гэрэл, цахилгаан	10,818,600	10,818,600
210302	Түлш, халаалт	88,434,800	88,434,800
210303	Цэвэр, бохир ус	21,666,600	14,650,384
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	31,115,800	30,377,260
210401	Бичиг хэрэг	11,385,700	11,386,300
210402	Тээвэр, шатахуун	15,177,400	15,187,400
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,258,700	3,578,560
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	294,000	225,000
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	835,900	810,340

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	835,900	810,340
<b>2106</b>	<b>Эд хөгшил, урсгал засварын зардал</b>	2,319,600	2,134,420
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	244,700	-
210604	Урсгал засвар	2,074,900	2,134,420
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,443,600	1,783,900
210702	Дотоод албан томилолт	2,443,600	1,783,900
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	314,337,700	313,444,888
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	312,013,500	311,896,038
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	421,200	-
210803	Даатгалын үйлчилгээ	638,100	283,950
210804	Тээврийн хэрэгслийн татвар	404,900	404,900
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	90,000	90,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	600,000	600,000
210807	Газрын төлбөр	170,000	170,000
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	71,377,000	71,319,884
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,377,000	69,350,084
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000	1,969,800
<b>212</b>	<b>ТАТААС</b>	45,000,000	45,000,000
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	-	-
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	45,000,000	45,000,000
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	45,000,000	45,000,000
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	45,660,000	45,592,794
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	45,660,000	45,592,794
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	38,888,200	38,888,200
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,771,800	6,704,594
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>295,650,000</b>	<b>178,518,400</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	295,650,000	178,518,400
220001	Барилга байгууламж	55,750,000	43,052,400
221001	Их засвар	89,000,000	20,000,000
222001	Тонот төхөөрөмж	82,900,000	49,997,500
223001	Бусад хөрөнгө	68,000,000	65,468,500
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,574,686,200	1,447,912,270
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,569,691,200	1,442,514,270
132001	Орон нутгийн төсвөөс	1,569,691,200	1,442,514,270
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	-	-
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	4,995,000	5,398,000
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,995,000	5,398,000
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>193,860,342.00</b>	<b>123,120,581.00</b>

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>83,316,053.00</b>	<b>89,046,520.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	83,316,053.00	54,046,520.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	3,750,000.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	3,750,000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	54,662,355.00	47,646,520.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,662,355.00	47,646,520.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	24,903,698.00	6,400,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,021,448.00	6,400,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,882,250.00	
<b>212</b>	<b>ТАТААС</b>	-	35,000,000.00
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	-	35,000,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас		35,000,000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,109,872.00</b>	<b>13,488,227.00</b>
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	2,109,872.00	13,488,227.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>108,434,417.00</b>	<b>20,585,834.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	108,434,417.00	20,585,834.00
220001	Барилга байгууламж		20,585,834.00
223001	Бусад хөрөнгө	108,434,417.00	
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	193,860,342.00	123,120,581.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	193,860,342.00	123,120,581.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	124,384,321.00	71,585,834.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,337,075.00	21,943,904.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	50,138,946.00	29,590,843.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Үйлдвэрлэл бизнест ээлтэй орчин бүрдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжиж, орон нутгийн бие даасан байдлыг бий болгох, төсвийн үр ашигтай бодлогыг хэрэгжүүлэх, Ховд хотын инженерийн шугам сүлжээний найдвартай, тасралтгүй байдлыг хангаж, хотын өсөн нэмэгдэж буй хэрэгцээг ханган, зам, талбайг нэмэгдүүлж, тохижилт, үйлчилгээний чанар, нийтийн орон сууцны тохижилтыг сайжруулан иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, малын генетик нөөцийн тухай хууль, Монгол мал үндэсний хөтөлбөр зэрэг мал аж ахуйн чиглэлээр гарсан хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах,

газар тариалан, үйлдвэрлэл, хүнсний аюулгүй байдлын холбоотой хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах дэвшилтэт техник тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, хүнс, худалдаа үйлчилгээ, хөнгөн үйлдвэр, жижиг дунд үйлдвэрлэлийн салбарын талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, экологийн тэнцвэрт байдлыг хадгалсан эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх, байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах замаар ногоон хөгжлийн загвар хот болох, ногоон эдийн засагт түшиглэсэн, бүс нутгийн үр ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэсэн, хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх, орон нутгийн бие даасан байдлыг бий болгох төсвийн үр өгөөжтэй бодлогыг хэрэгжүүлэх, төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг үр өгөөжийг нэмэгдүүлэх, санхүүгийн хариуцлагыг дээшлүүлж, төсвийн ил тод байдлыг хэрэгжүүлэх зорилго зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Аймгийн засаг даргын 2022 оны 4 дүгээр сарын 19-ний А/208 дугаар захирамжаар “Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоо”-г баталсны дагуу 24, багийн дарга 12, багийн нийгмийн ажилтан 12, нийт 48 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

“Төрийн үйлчилгээний нэгдсэн төв” байгуулж, орон зайнаас үл хамааран төрийн үйлчилгээг нэг дороос авах боломжийг бүрдүүлэн Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгагдсан мэдээлэл, харилцаа холбооны орчин үеийн технологи, цахим мэдээлэл солилцооны нэгдсэн системийг төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрүүлж, ажлын бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх замаар төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор “Цахим Ховд” дэд хөтөлбөр боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 68 дугаар тогтоолоор батлуулж, “smart khovd” гар утасны аппликейшн, нэг биллийн систем зэрэг технологийн дэвшил, инновац нэвтрүүлэхээр тусган, хэрэгжүүлж эхэлсэн байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, Шилэн дансны тухай зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 4 удаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 1 удаа, Төсвийн тухай хуульд 6 удаа, Шилэн дансны тухай хуульд 1 удаагийн өөрчлөлт оржээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Жаргалант сумын засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 10-ны А/112 дугаар “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үзлэг тооллого явуулах тухай” тушаалаар 4 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилон ажиллуулсан байна. Ажлын хэсэг хагас жилийн байдлаар хөрөнгө тооллогоор дутагдсан ус буцалгагч 1 ширхгийг төлүүлэх, 3.5 сая төгрөгийн үнэ бүхий цоохор гэр 1 ширхэг, компьютер 1 ширхэг хүлээлгэж өгөөгүй тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн ч хэрэгжилт хангагдаагүй, жилийн эцэст хөрөнгийн тооллого хийгээгүй байна.

2022 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Ховд аймгийн Тамгын газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/12 дүгээр тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгө бүртгэн авах санал дүгнэлтийг гаргажээ.

Өмч хамгаалах зөвлөлийг 2021 оны 12 дугаар сарын 27-ны А/48 дугаар тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан боловч 2022 онд ямар нэгэн ажил зохион байгуулаагүй байна.

2022 онд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2020-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийж шалгалтаар 121.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 26.1 сая төгрөгийг аймгийн төсөвт оруулахаар, 16.5 сая төгрөгийг орлого авч данс бүртгэлд тусгуулахаар, 77.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн байна.

Шалгалтаар АЗ сургалтын гэрчилгээний үнийг байгууллагаас төлүүлсэн 50 хүнтэй холбоотой 3.2 сая, тэтгэмж урамшууллын 55 хүнтэй холбоотой 19.9 сая, цалин хөлс төлүүлэх 0.5 сая, урьдчилгаа цалин буцааж суутгаагүй 2 хүнтэй холбоотой 2.5 сая төгрөг нийтдээ 26.1 сая төгрөгийн акт, ном сэтгүүлийн үнэ орлого авах 15.0 сая төгрөг, хөрөг зураг орлого аваагүй 1.5 сая нийтдээ 16.5 сая төгрөгийн хөрөнгө орлого авах зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 390.5 сая төгрөгөөр буюу 9.3 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1

Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	276.80	132.38	(144.4)
Урьдчилгаа	26,108.90	36,908.90	10,800.0
Бараа материал	54,468.50	99,335.65	44,867.2
Үндсэн хөрөнгө	4,074,669.90	4,409,652.83	334,982.9
Нөөцийн бараа	-	-	-
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,155,524.10</b>	<b>4,546,029.76</b>	<b>390,505.7</b>
Өр төлбөр	11,237.84	20,894.2	9,656.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,144,286.20	4,525,135.6	380,849.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>4,155,524.04</b>	<b>4,546,029.76</b>	<b>390,505.7</b>

Дээрх хүснэгтээс харахад Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх авлагын дүн өмнөх оноос 144.4 мянган төгрөгөөр буурч, урьдчилгаа 10,800.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн материаллаг нөлөө нь авлагын данстай холбоотой байна.

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Авлага оны эхэнд 0.2 сая төгрөг байсан бол оны эцэст 0.1 сая, урьдчилгаа 36.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь он дамжсан хувь хүнээс авах авлага, урьдчилгаа нь өмнөх оны тайлангийн үлдэгдэл цалингийн урьдчилгаа 3.9 сая, тайлант онд олгоод буцааж суутгаагүй урьдчилгаа цалингийн үлдэгдэл 2.4 сая, үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа 30.5 сая төгрөг зэрэг авлагыг бүртгэсэн байна.
- ✓ Бараа материал 54.4 сая төгрөг байсан бол 99.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Тус онд 130.5 сая төгрөгийн материал нэмэгдэж, 85.7 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна.
- ✓ Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,074.7 сая байсан тайлант онд 503.3 сая төгрөгийн хөрөнгө авч 168.3 сая төгрөгийн элэгдэл байгуулж, 4,409.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ✓ Оны эхэнд 11.2 сая төгрөгийн өр төлбөртэй байсан бол оны эцэст 20.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 4.4 сая төгрөг, бэлтгэн нийлүүлэгчид төлөх 0.9 сая, хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг 14.5 сая, бусад 0.9 төгрөгийн өглөгтэй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,569.7 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 4.9 сая, нийт 1,574.6 төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 41.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,569.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, туслах үйл ажиллагааны орлогоос 4.9 сая төгрөг нийт 1,574.7 сая төгрөг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр 2022 онд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,442.5 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 5.4 сая, нийт 1,447.9 сая төгрөг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,447.9 сая төгрөг буюу 92 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 126.8 сая төгрөгөөр тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага / үндсэн үйл ажиллагаа 70106/80101	455,242.00	446,979.90	8,262.10	98.15
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага / гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ 70106/80103	72,716.50	72,716.50	0.00	100.00
3	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага / гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ 70106/80106	308,175.90	306,980.40	1,195.50	99.61
4	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага / мэдээлэл сурталчилгааны зардал 70106/80205	3,203.50	3,201.50	2.00	99.94
5	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага / харуул хамгаалалт 70106/80219	835.90	810.30	25.60	96.84
6	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага / ажил олгогчоос олгох тэтгэмж, дэмжлэг урамшуулал 70106/80802	44,939.00	44,872.60	66.40	99.85
7	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага / орон нутгийн нөөц хөрөнгө 70106/81102	37,248.40	37,248.20	0.20	100.00
8	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага / орон нутгийн нийтийн тээвэр 70106/80406	45,000.00	45,000.00	0.00	100.00
9	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага / орон нутгийн хөрөнгө оруулалт 70106/80918	295,650.00	178,518.40	117,131.6	34.39
10	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага / орон нутгийн хөрөнгө оруулалт 70106/882214	274,426.60	274,336.10	90.50	99.97
11	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага / Бараа үйлчилгээний бусад зарда 70106/81701	37,248.40	37,248.40	0.00	100.00
<b>ДҮН</b>		<b>1,574,686.20</b>	<b>1,447,912.30</b>	<b>126,773.90</b>	<b>91.24</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 71.6 сая, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 21.9 сая, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 29.6 сая, хийтдээ 123,1 төгрөг бүрдүүлж, 109.6 сая төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 13.5 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор Д.Энхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 2/51 албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,612.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 24.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 19.3 сая төгрөгөөр тогтоов.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хоригдсон мөнгөн аяга, бэлэг дурсгалын зүйлстэй холбоотой 2.4 сая, шагнал

урамшуулал хэлбэрээр 2.1 сая, уран бүтээлчид дэмжлэг 4.5 сая, ном контент 16.6 сая төгрөг зарцуулсан, шатахууны үрэлгэн зарцуулалтад хяналт сул хэрэгжүүлсэн зэрэг зөрчлүүд илэрсэн тул тайлангийн 5,6 дугаар бүлэгт бичлээ.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 140 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 19 байна.

Шилэн дансны төлөвлөгөө боловсруулан баталж, 11 сарын гүйцэтгэлээр сумын төсвийн шууд захирагч нарын 4 байгууллагын 530 мэдээлэл байршуулахаас 521 мэдээлэл байршуулсан байна. Нийт байршуулсан мэдээллийн 376 мэдээллийг хуулийн хугацаанд, 145 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь 96.3 хувийн биелэлттэй байна. Харин сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд шилэн дансанд 139 мэдээлэл байршуулахаас 139 мэдээлэл байршуулан байршуулсан мэдээллийн 124-ийг хуулийн хугацаанд 15 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар түрээсийн орлогын 30 хувь төвлөрүүлээгүй 1.4 сая, 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар түрээсийн орлогын 30 хувь төвлөрүүлээгүй, ачаа тээврийн зардалд илүү зардал гаргасан 1.3 сая, нийтдээ 2.7 сая төгрөгийн акт тогтоосныг төлж барагдуулаагүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	2744.0	0	0	0
Албан шаардлага					
Зөвлөмж					
<b>Нийт дүн</b>	<b>8</b>	<b>1,196.3</b>	<b>6</b>	<b>955.8</b>	<b>79.9</b>

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар шатахууны тооцоо, өвсний тооцоо, Хайрхан багт байрлах /7-р сургуулийн дэргэдэх/ халуун усны түрээсийн тооцоо, бичигт багт ашиглалтад орж байгаа халуун усны ашиглалт зэргийг анхааран авч үзэх шаардлагатай.

#### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 949.9 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрсэн тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтын дагуу санхүүгийн тайланд залрууллаа.

- Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дунгийн тайлан, тодруулга тайланд хөрөнгө бүртгээгүй 949.9 сая төгрөгийн залруулга хийж аймгийн тайланд нэгтгэлд авлаа.

Аудитаар нийт 149.1 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 52.7 сая төгрөгийн 4 зөвлөмж, 90.6 сая төгрөгийн 3 албан шаардлага, 3.1 сая төгрөгийн 1 акт тогтоолоо.

##### **5.1 Төлбөрийн акт**

- *Тайлант онд орсон түрээсийн орлого 7.8 сая төгрөгөөс 40 хувь болох 3.2 сая төгрөгийг орон нутгийн өмчийн алба руу төвлөрүүлээгүй нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 50 дугаар тогтоолоор "Түрээслүүлэгч нь түрээсийн төлбөрийн 40 хувийг төлбөр орсноос хойш ажлын 5 өдрийн дотор улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлнэ", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 41 дүгээр зүйлийн 41.2.1-д хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх*

##### **5.2 Албан шаардлага**

###### **5.2.1 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал**

- *2022 онд мөнгөн аяга гэх зэрэг бэлэг дурсгалын зүйлд 2.5 сая төгрөг төлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.5-д "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;"-ыг хориглоно гэснийг зөрчиж байна.*
- *Аймгийн татварын хэлтсийн байцаагч нарт 1.5 сая, хамтарсан багийн гишүүдэд 0.6 сая төгрөгийн урамшуулал олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэснийг зөрчиж байна.*

###### **5.2.2 Шатахууны зарцуулалттай холбоотой асуудал**

- *Жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодолгүйгээр 6.1 сая төгрөгийн шатахуун зарцуулсан, Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд авто машин хэрэглэхгүй албан тушаалтан хот дотор авто машин унасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны*

баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно" гэсэн заалтыг зөрсөн

### **5.2.3 Нийтийн тээврийн автобусны гэрээний үүргийн биелэлтийн талаар**

- *Жаргалант сумын Засаг дарга, Бат хөсөгтөн ХХК-тай "Жаргалант суманд нийтийн автобус тээврийн үйлчилгээ явуулах ажил гүйцэтгэх" гэрээ байгуулан тайлант онд 80.0 сая төгрөгийн санхүүжилт олгожээ. Дээрх гэрээний үүргийн биелэлт тооцоогүй, иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлсэн үр дүн тодорхойгүй, олгосон санхүүжилтийн гүйцэтгэлд хяналт тавиагүй, анхан шатны баримт хангалтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7-т "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.*

## **5.3 Зөвлөмж**

### **5.3.1 Анхан шатны баримт, зарцуулалтын тайлантай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тамгын газрын 2022 оны 2 сарын 25-нд номын үнэ шилжүүлсэн 0.6 сая төгрөг анхан шатны баримтгүй, Тамгын газрын 2022 оны 4 сарын 27-нд сургалтын зардал нэрээр олгосон 0.4 сая төгрөг анхан шатны баримтгүй, Тамгын газраас 2022 оны 5 сарын 9-нд Аэромонголиа ХХК-д шилжүүлсэн Цогтбаярын замын зардал 0.5 сая төгрөг анхан шатны баримтын бүрдэл хангагдаагүй байгаа нь зэрэг зөрчлүүд илэрч байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэснийг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Төсвөөс зарцуулж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний анхан шатны баримт, гэрээ, гүйцэтгэлийн баримтуудыг бүрэн хүлээн авах, баримтгүй гүйлгээг тусгахгүй байх.

### **5.3.2 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

- *Ховд цахилгаан түгээх сүлжээ ХХК-тай гэрээ байгуулан "Гэр хорооллын айл өрхүүдийн цахилгааны хүчдэл нэмэгдүүлэх" ажлын санхүүжилт 2022 оны 6 сарын 29-нд 14.0 сая төгрөг шилжүүлсэн боловч зарцуулалтад хяналт хийгээгүй, гэрээний үүргийн биелэлт тооцоогүй, энэ ажил дууссан эсэх нь тодорхойгүй*
- *Ховд цахилгаан түгээх сүлжээ ХХК-тай гэрээ байгуулан "Цахилгаан эрчим хүчний 0.4-ийн шугам татах" ажлын санхүүжилт 2022 оны 6 сарын 29-нд 14.0 сая төгрөг шилжүүлсэн боловч зарцуулалтад хяналт хийгээгүй, гэрээний үүргийн биелэлт тооцоогүй, энэ ажил дууссан эсэх нь тодорхойгүй.*

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар шатахууны тооцоо, өвсний тооцоо, Хайрхан багт байрлах /7-р сургуулийн дэргэдэх/ халуун усны түрээсийн тооцоо, бичигт багт ашиглалтад орж байгаа халуун усны ашиглалт зэргийг анхааран авч үзэх шаардлагатай.

#### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 949.9 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрсэн тул Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтын дагуу санхүүгийн тайланд залрууллаа.

- Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, тодруулга тайланд хөрөнгө бүртгээгүй 949.9 сая төгрөгийн залруулга хийж аймгийн тайланд нэгтгэлд авлаа.

Аудитаар нийт 149.1 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 52.7 сая төгрөгийн 4 зөвлөмж, 90.6 сая төгрөгийн 3 албан шаардлага, 3.1 сая төгрөгийн 1 акт тогтоолоо.

##### **5.1 Төлбөрийн акт**

- *Тайлант онд орсон түрээсийн орлого 7.8 сая төгрөгөөс 40 хувь болох 3.2 сая төгрөгийг орон нутгийн өмчийн алба руу төвлөрүүлээгүй нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 50 дугаар тогтоолоор "Түрээслүүлэгч нь түрээсийн төлбөрийн 40 хувийг төлбөр орсноос хойш ажлын 5 өдрийн дотор улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлнэ", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 41 дүгээр зүйлийн 41.2.1-д хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх*

##### **5.2 Албан шаардлага**

###### **5.2.1 Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал**

- *2022 онд мөнгөн аяга гэх зэрэг бэлэг дурсгалын зүйлд 2.5 сая төгрөг төлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.5-д "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;"-ыг хориглоно гэснийг зөрчиж байна.*
- *Аймгийн татварын хэлтсийн байцаагч нарт 1.5 сая, хамтарсан багийн гишүүдэд 0.6 сая төгрөгийн урамшуулал олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэснийг зөрчиж байна.*

###### **5.2.2 Шатахууны зарцуулалттай холбоотой асуудал**

- *Жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодолгүйгээр 6.1 сая төгрөгийн шатахуун зарцуулсан, Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд авто машин хэрэглэхгүй албан тушаалтан хот дотор авто машин унасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны*

- Тамгын газраас 2022 оны 12 сард Нэлко ХХК-тай "Дэлгэцийн хамаарал, донтолтоос хамгаалах арга хэмжээ" нэрээр 15.0 төгрөгийн гэрээ байгуулан 13.6 төгрөг шилжүүлсэн боловч данс бүртгэлд буруу тусгасан, ном авсан гэж байгаа боловч анхан шатны баримт байхгүй, номыг орлого авч данс бүртгэлд тусгаагүй
- Тамгын газраас 2022 оны 9 сард иргэн Бадраад 0.5 сая төгрөг, Баян ану БГБХ Нөхөрлөлд 1.4 сая төгрөг шилжүүлэн "Нийтийн эзэмшлийн зам талбай, хашлага хайс будах" ажил хийлгэсэн боловч гүйцэтгэлд хяналт тавиагүй. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.1-т "Нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар зарцуулна", 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна"-г зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгө зарцуулахдаа Засаг даргын захирамжийн хүрээнд Төсвөөс зарцуулж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээний анхан шатны баримт, гэрээ, гүйцэтгэлийн баримтуудыг бүрэн хүлээн авах, баримтгүй гүйлгээг тусгахгүй байх. Сургуулиудад олгосон номыг бүрэн орлого авч бүртгүүлэх

### **5.3.3 Төрийн хэмнэлтийн хууль, төсвийн зарцуулалттай холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

- Тамгын газраас 2022 оны 12 сард Н.Цолмонд уран бүтээлийн дэмжлэг болгон 4.5 сая төгрөг олгосон
- Тамгын газраас 2022 оны 12 сард Урлан гучин гурван филмс ХХК-тай "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ" нэрээр гэрээ байгуулан 3.0 сая төгрөг шилжүүлсэн боловч бэлтгэсэн контентоо бүрэн хүлээж аваагүй, зарцуулалтад хяналт тавиагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх"-г зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хөтөлбөр, арга хэмжээнд тусгагдсан ажлуудад төсвийн хөрөнгийг зарцуулах. Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэх.

### **5.3.4 Бараа материал үндсэн хөрөнгө түүнд тавих хяналтын талаар**

#### Илрүүлэлт:

- Бараа материал үндсэн хөрөнгийн тооллогыг жилийн эцэст хийгээгүй, хагас жилээр дутагдсан хөрөнгийн асуудлыг шийдвэрлээгүй, шинээр бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1."Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна". 12.2."Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ": 12.2.3."эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед" гэсэн тэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материал үндсэн хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд хийж, дутагдсан хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж байх

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Үүнээс	
					Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аймгийн ИТХ-н болон ТӨБЗГ-н тогтоол гарсан нийт 8 хөрөнгийг дансанд бүртгээгүй	1	949,900.0	-	-	1	949,900.0
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>949,900.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>949,900.0</b>

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Зөвлөмж		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Түрээсийн орлого төвлөрүүлэх	1	3,150.2	1	3,150.2				
Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал	1	4,550.0					1	4,550.0
Нийтийн тээврийн автобусны гэрээний үүргийн биелэлтийн талаар	1	80,000.0					1	80,000.0
Анхан шатны баримт, зарцуулалтын тайлантай холбоотой асуудал	1	1,510.2			1	1,510.2		
Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал	1	43,602.4			1	43,602.4		
Хөрөнгийг жилийн эцэст тоолж тооцоо хийгээгүй, хагас жилээр дутагдсан хөрөнгийн асуудлыг шийдвэрлээгүй	1				1			
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>132,812.8</b>	<b>1</b>	<b>3,150.2</b>	<b>3</b>	<b>45,113.6</b>	<b>3</b>	<b>84,550.0</b>

Нийцлийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй	-	-	-	-	-	-	-	-
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн хууль, төсвийн зарцуулалттай холбоотой асуудал	1.0	7,500.0	-	-	-	-	1.0	7,500.0
Шатахууны зарцуулалттай холбоотой асуудлаар	1.0	6,096.0			1.0	6,096.0		
Дүн	1.0	13,596.0	-	-	1.0	6,096.0	1.0	7,500.0
Нийт дүн	1.0	13,596.0	-	-	1.0	6,096.0	1.0	7,500.0

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Д.БОЯДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:



117141032

9066454

Д.ЭНХЖАРГАЛ



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 64/А.21.4128

Ховд

ХОА-2022/129/-НА-СТА-ТШЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жаргалант сумын Тамгын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд тайлант онд орсон түрээсийн орлого 7875600 төгрөгөөс 40 хувь 3150240 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 50 дугаар тогтоолоор "Түрээслүүлэгч нь түрээсийн төлбөрийн 40 хувийг төлбөр орсноос хойш ажлын 5 өдрийн дотор улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлнэ", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 3150240 /гурван сая хоёр зуун тавин мянган хоёр зуун дөчин төгрөг/-ийг Төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 06 дугаар сарын 10-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Жаргалант сумын Тамгын газрын дарга Х.Баярлах, нягтлан бодогч Х.Ганболд нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

АХЛАХ АУДИТОР

Д.ЭНХЖАРГАЛ



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 40/А.2171/28

Ховд

ХОА-2022/129/НА-СТА-ТШЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жаргалант сумын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд аудит хийхэд Жаргалант сумын Засаг дарга, Бат хөсөгтөн ХХК-тай "Жаргалант суманд нийтийн автобус тээврийн үйлчилгээ явуулах ажил гүйцэтгэх" гэрээ байгуулан тайлант онд 80.0 сая төгрөгийн санхүүжилт олгожээ. Дээрх гэрээний үүргийн биелэлт тооцоогүй, иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлсэн үр дүн тодорхойгүй, олгосон санхүүжилтийн гүйцэтгэлд хяналт тавиагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7-т "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлдэггүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой тус компанитай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг хангах, үйлчилгээ үзүүлсэн үр дүнг тодорхой тооцож санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн, гүйцэтгэлийг зориулалтын дагуу нотлох баримтад тулгуурлан олгож албан шаардлагын биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 10-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>3</sup> ирүүлэх.
2. Цаашид дээрх зөрчилтэй холбоотой алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, ажилтнуудын ажлын хариуцлагыг дээшлүүлж хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тамгын газрын дарга Х.Баярлах, нягтлан бодогч Х.Ганболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Д.ЭНХЖАРГАЛ

<sup>1</sup> Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 25 өдөр

ХОА-2022/129-НА-СТА-ТШЗ

Ховд

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жаргалант сумын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд аудит хийхэд бэлэг дурсгалын зүйлд 2.5 сая төгрөг төлсөн, аймгийн татварын хэлтсийн байцаагч нарт 1.5 сая, хамтарсан багийн гишүүдэд 0.6 сая төгрөгийн урамшуулал олгосон зэрэг зөрчлүүд илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулан Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах ажиллаж албан шаардлагын биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 10-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэх.
2. Цаашид дээрх зөрчилтэй холбоотой алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, ажилтнуудын ажлын хариуцлагыг дээшлүүлж хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тамгын газрын дарга Х.Баярлах, нягтлан бодогч Х.Ганболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

АХЛАХ АУДИТОР

Д.ЭНХЖАРГАЛ



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар

12/АДТН/2023

Ховд

ХОА-2022/129/НА-СТА-ТШЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жаргалант сумын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд аудит хийхэд жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодолгүйгээр 6.1 сая төгрөгийн шатахуун зарцуулсан, авто машин хэрэглэх эрхгүй албан тушаалтан хот дотор авто машин зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой жолоочийн замын хуудсаар шатахууны тооцоог сар бүр хийж, Төрийн хэмнэлтийн хуульд зааснаас бусад албан тушаалтан хот дотор машин унаж шатахуун зарцуулахгүй байх, төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулах, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах. Албан шаардлагын биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 10-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэх.
2. Цаашид дээрх зөрчилтэй холбоотой алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, ажилтнуудын ажлын хариуцлагыг дээшлүүлж хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тамгын газрын дарга Х.Баярлах, нягтлан бодогч Х.Ганболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Х.БОЛДВААТАР

Д.ЭНХЖАРГАЛ

<sup>1</sup> Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061